

СОНГУУЛИЙН ПРОГНОЗ ХИЙХ АРГА ЗҮЙ: АСУУДАЛ, ХУВИЛБАР, АРГА

(Сонгуулийн социологи, сонгогчийн зан үйлийн шинжилгээ)

Ц.Болд, Ч.Тамир

Нэг. Сонгуулийн прогноз хийх үндсэн нөхцөл: тооцох хүчин зүйлс.

Сонгуулийн дүнг прогнозчилох явдал сүүлийн жилүүдэд судлаачдын анхаарлыг ихэд татаж байна. Энэхүү судалгааг наад зах нь нэгдүгээрт иргэдийн сонгуулийн оролцоо¹²⁸, хоёрдугаарт тойргийн хэв шинж, онцлогийн судалгаа¹²⁹, гуравдугаарт, улс төрийн намуудын рейтинг, дөрөвдүгээрт сонгуулийн булхай¹³⁰ луйвар, тавдугаарт сонгогчийн зан үйлийг бүрдүүлэгч хүчин зүйлсийн нөлөө, тэдгээрийн хэр хэмжээ¹³¹ зэргийг тусгасан цогц судалгаа хийж байж сонгуульд ямар нам хүчин амжилт үзүүлэх вэ? гэдэгт илүү бодитой хариулт өгч чадах юм. Чөлөөт сонгууль явуулж эхэлсэн 1990 оноос эхлээд сонгууль бүрийн өмнө аль нам хүчин сонгуульд ялалт байгуулах бол гэсэн мэтгэлцээн, маргаан өрнөж үүнд жирийн сонгогчоос эхлээд төрийн өндөр албан тушаалтнууд, зурхайчаас эхлээд судалгааны байгууллагын мэргэжилтнүүд идэвхийлэн оролцож иржээ. Нийгэмд өрнөж байгаа эл үйл явдлаас судлаачид хоцроогүй, хоцрох ч ёсгүй юм. Английн нэрт социологич Э.Гидденсийн хэлснээр социологийн шинжлэх ухааны нийгмийн өмнө гүйцэтгэдэг хүндтэй үүрэг бол прогнозчилол билээ. Чухам тийм учраас бид хамгийн их анхаарал татсан сэдэв болох сонгуулийн дүнг шинжлэх ухааны арга зүй, аргачлалыг ашиглан прогнозчилох оролдлого хийсний зарим хэсгээс толилуулж байна.

Өнөөдөр судлаачид сонгуулийн прогноз хийхдээ дараах аргыг л үндсэндээ ашиглаж байна. Одоогоор сонгуулийн судалгааг дагнан явуулж буй зарим судалгааны байгууллагын мэдээнээс¹³² үзвэл манай улсын сонгуулийн системийн онцлогтой уялдуулан 76 тойрогт тус бүрт нь судалгаа явуулж үүндээ тулгуурлан сонгуулийн дүнг урьдчилан гаргаж байна. Хэдийгээр энэ нь сайн арга мөн боловч маш их хөрөнгө, олон тооны мэргэжилтэн, багагүй цаг хугацаа шаарддаг нь бэрхшээлтэй. Мөн 2000 оны УИХ-ийн сонгуулийн дүнг экспертгийн судалгаан дээр тулгуурлан прогноз хийж байсан¹³³. Тэгвэл үүнээс өөр арга байж болох уу?

Чухам энэ асуултанд хариулахаас бидний судалгааны эрэл хайгуул эхэлсэн. Сонгогчийн зан үйл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс, ангилал, хэв шинж, тойргуудын шилжих хөдөлгөөн зэргийн талаар хийсэн судалгааны дүнгээс цуврал болгон нийтэлж байсан. Энэ нь сонгогчийн зан үйлд шинжилгээ хийх, сонгуулийн үр дүнг урьдчилан тооцоолох ажлын дөнгөж эхлэл байв. Улмаар сонгуулийн прогноз хийхдээ математик, статистикийн зарим нэг арга, мөн социологийн тодорхой судалгааны дүнг өөр хооронд нь уялдуулах, математик онолын хялбар загварыг ашиглах оролдлогыг хийж эхэлсэн. Мэдээж үүнд олон бэрхшээл гарсан. Наад зах нь манайд ардчилсан сонгууль явуулаад төдийлөн удаагүй учраас сонгуулийн зүй тогтлыг гаргах хэмжээний статистик тоо хуримтлаагүй, бага зэрэг тоо баримт байгаа боловч түүнд шинжилгээ хийгээгүй¹³⁴, хоёрдугаарт улс төрийн намуудын нэгдэх, ялгарах үйл явц хэт хурдан, бүрэн төлөвшөөгүй, гуравдугаарт сүүлийн гурван сонгуулийг эс тооцвол 1992 он болон 1990 оны сонгууль нь өөр систем хувилбараар явагдсан ба цаашид 2008 оны УИХ-ийн сонгуулийн өмнө сонгуулийн хууль өөрчлөгдөх магадлалтай, үүнтэй

128 Ц.Болд Ч.Тамир. Монгол дахь иргэдийн улс төрийн оролцооны хэв маягууд ба социаль төрх. "Альтернатив" сэтгүүл, /Улс төрийн шинжлэх ухааны сэтгүүл/

129 Ч.Тамир. Сонгогчийн зан үйл, ба ангилал, шилжих хөдөлгөөн. "Шинэ толь сэтгүүл", 38

130 Ч.Тамир. Улс төрчдийн хувь заяа ба булхайтай ардчилал. "МН-Өнөөдөр" сонин., 2004- 8-7

131 Д.Ганхуяг. Ц.Болд. Монгол дахь олон нийтийн санаа бодлын судалгаа ба псепологи, "Социологи" сэтгүүл. №2 2002

132 УИХ-ийн сонгуулийн өмнө 76 тойрогт МАХН-ын дэргэдэх Прогноз судалгааны төвөөс судалгаа хийсэн. Энэ судалгааны дүн Үнэн сонин 2004 оны 8-р сарын 5-ны дугаарт нийтлэгдсэн.

133 Энэ судалгааны материал зохиогчийн хувийн архивт хадгалагдаж байгаа.

134 1992 онд батлагдсан сонгуулийн тухай хуулийн дагуу Сонгуулийн Ерөнхий Хорооноос Сонгуулийн дүнг тодорхой хугацааны дотор олон нийтэд албан ёсоор зарладаг. Мөн СЕХ-ноос эрхлэн гаргасан "Ардчилсан төрийн сонгуулийн товчоон" 2000. УБ., гэсэн ном энэ чиглэлээр гарсан судалгааны Үндсэн статистикийн эмхэтгэл болсон.

уялдаад сонгуулийн үр дүнд нөлөөлөх хүчин зүйлс өөрчлөгдөж байдаг, зэрэг монголын улс төрийн нөхцөл байдлыг загварчлахад бэрхшээл учруулдаг олон шалтгааныг тоочиж болох юм.

Сонгуулийн прогноз гэдэг нь сонгуулийн үйл явцын өнгөрсөн болон одоогийн нөхцөл байдлын шинжилгээнд тулгуурлан түүний цаашдын хандлага үр дүнг урьдчилан таамаглах үйл явц. Тийм учраас энэ нь нэлээд төвөгтэй ажил юм. Үүнд сонгуулийн үйл явцаас тогтвортой хүчин зүйлсийг хэрхэн тогтоох, алийг нь сонгон авах, өөрчлөлт динамикийг хэрхэн гаргах гэх мэтчилэн онол, арга зүй, аргачлалын түвшинд сайтар боловсруулах шаардлагатай нарийн асуудал олон бий. Энэ бүгдийг нуршилгүйгээр¹³⁵ сонгуулийн дүнг математик хялбар загвараар тооцоолоход нөлөө үзүүлэх зарим хүчин зүйлсийн талаар товчхон дурдъя.

1. Улс төрийн хүчнүүдийн интеграци, дифференциацийн асуудал

Сонгогчийн зан үйл, сонгуулийн системийн талаар ямар нэгэн үнэлэлт дүгнэлт өгөхөд, цаг хугацааны өөрчлөлт дэх динамикийг гаргахад манайд явагдсан ардчилсан сонгуулийн тоо цөөхөн¹³⁶ ч урьдчилж тойм төдий ч гэсэн зүйлийг ярьж болохуйц цаг нэгэнт болжээ.

1990 оноос хойш манай улсад олон намын тогтолцоо бүрэлдэн бий болж өдгөө 15 жил өнгөрчээ. Дээрх хугацаанд улс төрийн амьдрал оргилон буцалж нам, хүчнүүд ихээхэн эрчимтэй өөрчлөгдөн хөгжиж байлаа. Үүнийг улс төрийн намууд шинээр үүсэх, өөр хоорондоо нэгдэх, дотооддоо ялгарах, салах зэрэг цаг хугацааны хувьд зэрэгцэн болон дараалан явагдсан олон үйл явдлаас харж болно. Мөн сонгуулийн өмнө улс төрийн намууд эвсэх явдал түгээмэл байлаа. Хамгийн томоохноос нь дурдахад 1996 онд Ардчилсан холбоо эвсэл, 2004 онд Эх орон-Ардчилал эвслийг байгуулж байв.

Гэвч энэ бүхнийг нэгтгэн багцалж үзвэл улс төрийн хүчнүүдийг хоёр ангилалд буюу МАХН ба Ардчиллын талынхан гэж хуваан үзэх үндэслэл бий. Тухайлбал МАХН гэхэд сонгууль болгонд оролцсон, өөрийн гэсэн электораттай, тогтвортой статик үзүүлэлттэй гэдгийг нэг тал болговол нөгөө талд ардчиллын талынхныг 1996 он ба 2004 онуудад сонгуульд оролцохдоо эвссэнийг иш үндэс болгож МАХН-тай өрсөлдөгч үндсэн хүч үзэж болно. Ингэж хуваах нь улс төрийн гуравдагч хүчний талаарх асуудлыг зүй ёсоор хөндөнө. Өнгөрсөн хугацаанд манай улс төрийн амьдралд (1996, 2004 онд) гуравдагч хүчин оршиж байсан түүх бий ч өөрийн электораттай нам гэдгээрээ бус харизматик лидер дагасан нэгдэл гэдэг тал нь давамгайлж байсан. Үүнийг амьдрал дээр улс төрийн гуравдагч хүчний оршин байх орон зай байхгүй хэмээн МАХН-ынхан ч, Ардчилалын талынхан ч ярьж бичдэг. Үнэхээр сонгогчдын ихэнхи нь энэ хоёр талд хуваагдаж санал өгдөг ба үүнийг өнгөрсөн сонгуулийн дүн ч баталдаг. (О.Дашбалбар, Х.Гүндалай, С.Оюун, Б.Эрдэнэбат, Б.Жаргалсайхан нар тодорхой цаг хугацаанд парламентад суудалтай байсан боловч бодитой улс төрийн гуравдагч хүчний тухай ярихад арай эрт байна.)

Дээр өгүүлсэнд үндэслэн Монголын улс төрд хоёр гол хүчин өрсөлддөг гэсэн санааг тулгуур болгож үзэж болно. Энэ нь **МАХН** ба **Ардчилсан хүчин** гэсэн ангилал юм.

2. Сонгуулийн ижил нөхцөл

Сонгуулийн прогноз хийхэд сонгуулийн систем ихээхэн хамаатай юм. Шинэ үндсэн хууль батлагдсанаас хойшхи арав гаран жилийн хугацаанд Монгол улсад Улсын Их Хурлын сонгууль 4 дэх удаагаа явагдаж өнгөрлөө. Хэрвээ 2004 оны сонгуулийг оролцуулвал сүүлийн 3 сонгууль нь яг нэг ижил нөхцөлд явагдсан юм. Сонгуулийн ижил нөхцөл гэдгийн дор бид сонгуулийн нэгэн хуулиар, сонгуулийн нэгэн ижил системд, нэгэн ижил тойргийн хуваарилалт, санал тооцох механизм зэргийг ойлгож байна. Өнөөдөр үйлчилж байгаа сонгуулийн хуулиар улс орныг 76 тойрогт хуваан тойрог болгонд улс төрийн хүчнүүд нэр дэвшүүлж өрсөлддөг. Нэг тойргийн дүнгээс нөгөө тойргийн дүн үл хамаарах ба тухайн тойрогт нэрийн жагсаалтанд бичигдсэн сонгогчдын олонхи (буюу 50+1) оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцож олонхийн санал авсан нэр дэвшигчийг ялсанд тооцно¹³⁷

135 Энэ тухай цуврал өгүүлүүд гарахаар төлөвлөж байгаа.

136 үүнийг сонгуулийн олон арван жилийн туршлагатай өрнөдийн орнуудтай харьцуулан хэлж байгаа болно.

137 1992 онд УИХ-ийн сонгуулийн тухай хуулийг баталсан.

(хамгийн доод тал нь 25+1 гэсэн үг.) Сонгуулийн тогтолцооны эл онцлогтой уялдуулан бид өөрсдийн загварыг сонгон авсан.

3. Намтай өөрийгөө адилтгах нь сонгогчийн зан үйлийн түлхүүр болох нь.

Өнгөрсөн сонгуулиудад судалгаа хийж үзэхэд ихэнхи сонгогчийн хувьд намын фон¹³⁸ хамгийн нөлөөтэй хүчин зүйл болдог нь анхаарал татаж байв. Үүнийг улс төрчид, судлаачид "Сонгуульд нөлөөлдөг хамгийн гол хүчин зүйл бол намын фон", "1996 оны сонгуульд эвслээс бор халзан хонь дэвшсэн ч ялах л байсан", "2000 онд МАХН-ын олон улс төрчид намын рейтингдээ татагдан эвслийн хүчтэй улс төрчдийг ялсан" гэх зэргээр ярьдаг нь оргүй зүйл биш бөгөөд улс төрийн социологичид үүнд ихээхэн ач холбогдол өгдөг. Сонгуулийн дүнгүүд ч үүнийг ихэнхдээ баталдаг. Маш энгийн тоо баримтаас үүнийг харж болно. Тухайлбал 1996 онд Ардчилсан Холбоо эвсэл ялсан, 2000 онд МАХН үнэмлэхүй ялалт байгуулсан нь сонгогчдын ихэнхи нь намд харьяалуулж, өөрийгөө адилтгаж саналаа өгсөнтэй холбоотой./ Гэвч намын хүчин зүйл нь сонгуульд нөлөөлдөг *цорын ганц хүчин зүйл* гэж туйлширвал хэтрүүлсэн хэрэг болно гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Чухам ингэж сонгогчийн зан үйлд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох нь намуудын рейтингийг сонгуулийн прогнозад ашиглах боломжтой болно.

Өгүүлэн буй арга зүйн зарим тодотголоо үүгээр өндөрлөөд бидэнд байгаа тоо мэдээ баримтыг ашиглан ямар аргаар прогноз хийж болох талаар өгүүлье.

Хоёр. Бернуллийн схемийг ашиглах нь.

Нийгмийн прогноз хийхэд маш олон янзын аргыг ашигладаг¹³⁹. Сонгуулийн прогноз хийхэд ямар аргыг ашиглаж болох вэ? Хэрвээ та энэ хэсгийн нэрийг анхааралтай ажигласан бол бидний сонгосон хувилбарыг мэдсэн байх. Бид сонгуулийн дүнг Бернуллийн схемийг ашиглан загварчилсан. Өмнө өгүүлснээс үндэслэн "Монголын улс төрд улс төрийн хоёр хүчин өрсөлддөг, энэ хоёр хүчний намын фон нь сонгуульд нөлөөлдөг гол хүчин зүйл мөн, мөн сонгуулийн аль нэг тойргийн дүн нь нөгөөгөөсөө үл хамаардаг гэсэн зарчмуудыг мөрдлөгөө болгон гаргаж авч болно. Чухам ингэж улс төрийн маш олон янзын үйл явцыг хоёр талд хуваан үзсэнээр Бернуллийн схемийг хэрэглэх боломжтой болно. Гэхдээ уг хийсвэрлэл нь монголын улс төрийн тогтолцоог хэтэрхий хялбарчилсан загварт оруулжээ гэсэн шүүмжлэл гарвал хүлээн авна.

Хялбар загвар-Бернуллийн схем.

Туршилтын дүнд /сонгуулийн дүнд/ A ба \bar{A} үзэгдлүүдийн зөвхөн нэг нь явагддаг / A нь МАХН/-ийн нэр дэвшигч ялах, \bar{A} нь Ардчилсан хүчнээс нэр дэвшигч ялах/ бөгөөд A үзэгдлийн илрэх /МАХН-аас нэр дэвшигч ялах/ амжилтын магадлалыг p гэе. Тэгвэл $P(A)=p$, $P(\bar{A})=q$, $p+q=1$ болно. Дээрх туршилтыг нэгэн ижил нөхцөлд /нэгэн ижил сонгуулийн ситемд/ олон дахин /76 тойрогт/ давтан хийснийг үл хамаарах /сонгуулийн аль нэг тойргийн дүн нөгөө тойргийн дүнгээс үл хамаарна/ туршилтуудын дараалал буюу Бернуллийн схем гэж нэрлэдэг.

Одоо уг загвараар өнгөрсөн сонгуулийн дүнг тооцож үзье. Ингэхдээ бид хоёр үзүүлэлтийг ашиглах болно. Нэгдүгээрт МАХН-ын рейтингийг амжилтын магадлалыг тооцохдоо ашиглаж үзье. 2000 онд УИХ-ийн сонгуулиар нийт сонгогчдын 51 хувь нь МАХН-ыг дэмжиж байсан бөгөөд үүнийг сонгуульд ялалт байгуулах боломж гэж үзвэл амжилтын магадлал нь $p=0.51$ байжээ. Дээрх Бернуллийн схем ёсоор¹⁴⁰ МАХН 2000 оны сонгуульд 72 тойрогт ялалт байгуулах магадлал нь 0 байгаа, (тэрбумны нэг нарийвчлалтайгаар). Харин хамгийн их магадлалтай тоо буюу авах суудал нь 39 байна. Үүнтэй яг адилаар 1996 оны сонгуулиар МАХН хэдэн суудал авах байсныг бодвол МАХН-

138 Үүнийг сонгогч намтай өөрийгөө адилтгах, намд өөрийгөө харьяалуулах гэдэг бөгөөд барууны судлаачдын party identification гэсэн ойлголтыг ийнхүү орчуулж байгаа болно.

139 Эрдэмтэдийн тооцоолсноор прогноз хийх 150 гаруй арга байдгаас 15-20 аргыг голлон хэрэглэдэг ажээ.

140 Бидний бодлоор Бернуллийн хялбар загварыг ашиглах нь хамгийн тохиромжтой.

г дэмжигчдийн нийт сонгогчдын дунд эзлэх хувь 40.5 хувь байсан гэдгээс үүдэн амжилтын магадлалыг $p=0.40$ гэвэл МАХН 31 суудал авах магадлалтай гэсэн дүн гарч байна. Энэ тоо бас л сонгуулийн дүнтэй зөрж байгааг харж болно. Энд яагаад зөрүү гарсан вэ? 2000 онд бидний тооцоосоор сонгогчдын тэн хагасаас жаахан илүү санал авсан МАХН, 39 суудал авах нь хамгийн их магадлалтай байсан боловч 72 тойрогт ялалт байгуулж, даруй 33 суудал илүү авсан бол, 1996 онд сонгогчдын 40.5 хувийн санал авч, 31 суудал авах хамгийн их магадлалтай байсан боловч 26 суудал авч, 5 суудал дутуу авсан ба аль аль тохиолдолд нь ялалт байгуулсан тал нь боломжоосоо илүү үр дүнг хүртжээ.

/Үүнийг хүснэгтээр харуулья./

	УИХ-ын сонгууль	МАХН-ыг дэмжигчдийн хувь	Амжилтын магадлал \bar{p}	МАХН-ын авч болох суудлын хамгийн их магадлалтай тоо	Сонгуулийн дүн
1	1996 оны сонгууль	40%	0.40	31	26
2	2000 оны сонгууль	51%	0.51	39	72
3	2004 оны сонгууль	48%	0.48	36	36

Яагаад ийм алдаа гарсан вэ? Сонгуульд нөлөөлөх намын фоны нөлөөг хөөрөгддөг одоогийн сонгуулийн системээс шалтгаалав уу? Сонгууль бүрийн дараа ялагдсан улс төрийн хүчний зүгээс манай нам тэдэн хувийн санал авсан мөртлөө цөөхөн суудал авсан, тэр нам сонгогчдын тал хувийн санал авсан мөртлөө үнэмлэхүй олонхи болчихлоо, монголын сонгогчдын тал хувийн санал, эрх ашиг хохирч байна гэх гомдол тасрахгүй. Ер нь можаритар систем сонгогчдын саналыг бүрэн төлөөлж чадахгүй байх элбэг¹⁴¹.

Мөн нөгөө талаас энэхүү хялбар загвар буюу Бернуллийн загвар маань Монголын УИХ-ын сонгуулийг загварчлахад учир дутагдалтай байна уу? эсвэл загварчлахдаа буруу үзүүлэлт сонгож авсан уу? гэсэн асуулт гарна. Үүнийг дараагийн гүйцээлтээс харна уу.

Бернуллийн схемд np тоонд ойрхон байх k тоо нь хамгийн их магадлалтай тоо байдаг. Хэрэв $np-q$ тоо бүхэл тоо биш бол $np-q < k_0 < np+p$ байх k_0 тоо хамгийн их магадлалтай тоо болно. Тухайлбал амжилтын магадлал 0.48 , $n=76$ гэвэл $k_0=0.48*76$ буюу 36 нь хамгийн их магадлалтай тоо болно.

2004 оны 5 сард МАХН-ыг дэмжигчдийн хувь 48¹⁴² хувьтай байсан бөгөөд амжилтын магадлалыг 0.48 гэж тооцож сонгуулийн дүнг Бернуллийн схемээр загварчилбал МАХН их хуралд 36 суудал авах магадлал хамгийн өндөр байсан юм¹⁴³. Гэвч энэхүү прогнозад бүрэн итгэж болох уу, манай хялбар загвар энэ жилийн сонгуулийн үр дүнг тооцоолоход хэр зэрэг тохирох бол гэдэгт хариулахад хүнд байлаа. Учир юу гэвэл гуравхан удаагийн сонгуулийн үйл явцаас үүдэн улс төрийн үзэгдлийн зүй тогтлыг гаргахад хэцүү, тиймээс энэхүү загвар маань хэт энгийн юм шиг санагдаж байсан. Бидний загвар нэг сонгуульд нэлээд дөхүү, нөгөө сонгуульд илэрхий зөрүүтэй, мөн 2004 оны сонгуульд захиалсан юм шиг таарсны учир юу вэ?

Сүүлийн 4 удаагийн УИХ-ийн сонгуулийг ажиглаж байхад МАХН-аас бусад намууд эвссэн үедээ тодорхой амжилтад хүрдэг гэдэг нь 1996 он ба 2004 онд сөрөг хүчнийхэн эвсэл байгуулан орж ялалт байгуулснаар батлагдсан бол тэд сонгуульд дан дангаар оролцвол МАХН үнэмлэхүй ялалт байгуулдаг гэдгийг 1992 он ба 2000 оны УИХ-ын сонгуулийн дүн харуулсан.

141 Сонгуулийн систем болгон өөрийн гэсэн сул болон давуу талтай байдаг. Сонгогчидод сонгуулийн бүх боломжийгнэгэн зэрэг бүрэн эдлүүлсэн тийм төгс сонгуулийн систем байдаггүй, байх ч боломжгүй гэдгийг судлаачид баталсан. Сонгуулийн можаритор систем сонгогчийн төлөөллийг бүрэн тусгаж чаддаггүй.

142 Социологийн академи төвийн судалгаа. 2004 он. /Яг энэ Үед БНУУХ-гээс Альтернатив төвтэй хамтран явуулсан судалгааны дүн үүнтэй ойролцоо гарч байсан./

143 Энэхүү прогнозыг 2004 оны 4 сард явагдсан "Альтернатив" семинар дээр болон, 2004 оны 5 сард зохиогдсон социологичдын VI симпозиум дээр Сонгуулийн прогноз хийх арга зүй: гэсэн илтгэлд танилцуулж байсан.

Үүнээс үүдэн энэхүү Бернуллийн схемээр сонгуулийн үр дүнг загварчилж урьдчилсан прогноз хийх боломжтой юм байна, гэхдээ тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан аль хүчин зүйлийг сонгон авахаас прогноз мань өөр өөрөөр гарч байв. Өөрөөр хэлбэл ардчилсан хүчний намууд эвссэн тохиолдолд МАХН-ын үзүүлэлтийг сонгон авч болох бол эвсээгүй тохиолдолд сөрөг хүчний намуудын дундаж рейтингийг (эсрэг үзэгдлийн магадлалаар тооцож, улмаар амжилтын магадлалыг тогтоох) харгалзан тооцох хэрэгтэй ажээ.

Ингэхгүйгээр амжилтын магадлалыг тооцоходоо МАХН-ын рейтингийг шууд авах нь сонгуулийн үр дүнг буруу гаргахад хүрч байна.

	1992 оны УИХ-ын сонгууль	1992 оны сонгуулийн дүн		2000 оны УИХ-ын сонгууль	2000 оны сонгуулийн дүн
1	МАХН	56.9%	1	МАХН	51.7%
2	МоАН-МҮДН, НН эвсэл	17.5%	2	МҮАН	13.4%
3	МСМН	3.7%	3	МСДН	9.1%
4	МСДН	10.1%	4	Эх Орон – МАШСН	11.0%
5	ММТНН	2%	5	МоАН	1.8%
6	МХӨНН	1.4%	6	ИЗН-НН	3.6%
7	МТТН	2%	7	БНН	4.2%
8	МХН	2.1%	8	Бие даагч ¹⁴⁴	2.9%
9	Бие даагчид ¹⁴⁵	3%			

Чухам үүнийг баримтлан дахин Бернуллын схемийн дагуу тооцож үзвэл дараах байдалтай байна. Жишээ нь 2000 онд МАХН-аас бусад намуудын рейтинг дунджаар 6.6 хувьтай байсан гэж үзвэл МАХН-ын нэр дэвшигч сонгуульд ялалт байгуулах амжилтын магадлал 0.51 биш, харин 0.93 болох юм. Бернуллийн схемд амжилтын магадлал $p=0.93$ байхад туршилтыг 76 удаа давтан явуулбал хамгийн их магадлалтай тоо нь 71 болох ажээ. Гиймээс МАХН 2000 оны сонгуульд 72 суудал авсан нь санамсаргүй зүйл биш, тэр тусмаа савалгаа ч биш зүй тогтлын шинжтэй зүйл байсан гэж дүгнэж болохоор байна. Ийнхүү сонгуулийн прогноз хийхэд Бернуллийн схемийг ашиглахдаа тухайн үеийн нам хүчний харьцаатай уялдуулан хоёр янзын хувилбарыг ашиглах боломжтойг анхаарах хэрэгтэй юм.

Гурав. 2004 оны сонгуулийн дүн зүй ёсных байсан уу эсвэл?

2004 оны сонгууль дараах хоёр хэлбэрээр явагдаж болох байлаа. Хэрвээ ардчилсан хүчнүүд эвсээгүй тохиолдолд сонгууль нэгдүгээр хувилбараар явагдана, харин эвссэн тохиолдолд сонгуулийн дүн хоёрдугаарт хувилбараар загварчлагдах байв. Одоо үүнийг сонгуулийн өмнө хийгдсэн судалгааны дүн дээр тулгуурлан авч үзье.

Нэгдүгээр хувилбар:

Хэрвээ 2004 оны сонгуулийн өмнө сөрөг хүчний намууд эвсэж чадаагүй бол, хэрвээ М.Энхсайхан ба Б.Эрдэнэбат, С.Оюун гэсэн гурвал хамтран ажиллаагүй бол, хэрвээ ардчилсан намын зарим улс төрчийн амнаас гараад байгаа манай нам дангаараа олонхи болж чадах байсан гэсэн бардам үгс биелэлээ олсон бол тэртээ 1992 ба 2000 он давтагдах байжээ.

2003 онд "Эх орон-Ардчилал эвсэл" байгуулагдахаас өмнөх болон байгуулагдаж эхлэх үеийн намуудын рейтинг дараах хувьтай байжээ.

144 2000 оны сонгуульд бусад намууд нийтдээ 2.1 хувийн санал авсан. Нам тус бүрээр 1.5 хувийн босгыг даваагүй тул тооцоололд оруулаагүй.

145 1992 оны сонгуульд МНН 0.6 хувийн санал, МШАН, МАН 0.8 хувийн санал авсан тул тооцоололд оруулаагүй. Бид 1.5 хувийн босгыг тавьсан болно.

	Нам эвсэл	Дэмжигчдийн хувь ¹⁴⁶
1	МАХН	47.3%
2	МАН	30.1%
3	МАШСН	10.5%
4	ИЗ-БНН	5.2%
5	Бусад	3.5%
6	Бие даагч	3.4%

	Нам эвсэл	Дэмжигчдийн хувь ¹⁴⁷
1	МАХН	47.9
2	Эх орон Ардчилал эвсэл	37.4%
3	ИЗ-БНН	6.5%
4	Бусад	3.7%
5	Бие даагч	4.5%

Дээрх судалгааны дүнгээс харвал 2003 оны 8 сарын үед МАХН 47 орчим хувьтай харин МАН 30 орчим хувьтай, МАШСН 10.5 хувьтай, ИЗН 5.2 хувьтай байв. Чухамдаа 12 сард уг харьцаа МАХН 48 орчим хувьтай, эвсэл барагцаагаар 44 орчим хувьтай болжээ. Дээрх судалгааны дүнгүүд нь, 2004 оны УИХ-ийн сонгуулийн үеэр МАХН 48%-ийн санал авсан, Эх орон-Ардчилал эвсэл сонгуульд нийт 44 хувийн саналыг татсан дүнтэй таарч байгаа бөгөөд үүнийг иш үндэс болгон тооцож үзэхүл сөрөг хүчний намуудын дундаж рейтинг 11.3 орчим хувь болж байв. Чухам үүнээс Бернуллын схемийн дагуу тооцон үзвэл МАХН-ын амжилтын магадлал 88.7 хувь болж сонгуульд 67 орчим суудал авч болзошгүй байжээ. Үлдсэн 9 суудлыг сөрөг хүчний намын лидерүүд хуваан авч ихэнхи тойрогт тэд бие биенээ хэрчин¹⁴⁸ унагаж завсраас нь МАХН-ын нэр дэвшигчид цойлон гарч ирж болзошгүй байжээ.

	УИХ-ын сонгууль	МАХН-ыг дэмжигчдийн хувь	Бусад намуудыг дэмжигчдийн дундаж хувь q	Амжилтын магадлал p	МАХН-ын авч болох суудлын хамгийн их магадлалтай тоо	Сонгуулийн дүн
1	1992 оны сонгууль	56.9%	4.6	0.95	72	70
2	2000 оны сонгууль	51%	6.6	0.93	71	72
3	2004 оны сонгууль /хэрвээ сөрөг хүчний намууд эвсээгүй бол	48%	11.3	88.7	67	36

Энэ бол тун ойрхон байсан зүйл. Бидний тооцоолсноор анх сонгуульд эвсэж оролцох тухай 2004 оны цагаан сараар зарласнаас хойш нэлээд хэдэн удаа эвсэл задрах шахсан гэдгийг дурдах хэрэгтэй болов уу. Чухам тийм ч учраас сонгуулийн дараах эвслийн задрал санамсаргүй зүйл биш байв.

Хоёрдугаар хувилбар:

Гэвч сонгууль нэгдүгээр хувилбараар өрнөсөнгүй. Сөрөг хүчин эвсэж байж амжилтанд хүрнэ гэдгээ сайн ойлгосон байна. Тэд 1996 онд эвсэж ороод ямар ялалт байгуулж байснаа санаж байв. Тийм учраас 2004 оны сонгуулийн дүнг 1996 оны сонгуулийн дүнтэй харьцуулан үзэж болох юм.

146 2003 оны 8 сард Булган, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн 350 респондентоос авсан анкетийн судалгаа. "Социологийн академи" төв.

147 2003 оны 12 сард Улаанбаатар хотын 380 респондентоос авсан анкетийн судалгаа. Социологийн тэнхмийн дэргэдэх "Парадигм" төв.

148 Энэ тухай Ардчилсан хүчний улс төрч Б.Дэлгэрмаагийн "Их долоо" хэмээх өгүүлэл "Үг" сонины 2001 оны 33-р дугаарт нийтлэгдсэн.

Ямар боловч сонгуулийн өмнө сөрөг хүчний намууд өөр хоорондын асар их зөрчил, гомдол, шархаа нуун эвсэхийн төлөө зүтгэсэн. Өөрөөр хэлбэл М.Энхсайхан Ардчилсан хүчний гол намуудыг нэг эвсэлд нэгтгэж хүчийг зангидаж чадсаны үр дүнд сонгуулийн үр дүнг 2-р хувилбараар явагдах боломжийг бүрдүүлж, нийлбэр эрх ашгийг байж болох максимум үр дүнд хүргэж чадсан байна.

	УИХ-ын сонгууль	МАХН-ыг дэмжигчдийн хувь	Эвслийн намуудыг дэмжигчдийн хувь	Амжилтын магадлал р	МАХН-ын хамгийн их магадлалтай тоо	Сонгуулийн дүн
1	1996 оны сонгууль	40,5%	46.48%	0.40	31	26
2	2004 оны сонгууль	48%	44%	0.48	36	36

Хэдий ийм ч эвсэл болон МАХН-ын аль алинд нь одоогийн суудал дээр нэмээд 2-3 суудал авах боломж байсныг үгүйсгэхгүй. Тухайлбал эвслийн удирдлага тойргийн хуваарилалтан дээр алдаа гаргасан. Ер нь Эх орон-Ардчилал эвсэл байгуулагдахдаа тойргийн квот дээрээ багагүй маргаж, зөрчил үүссэн. Гэвч урт удаан хугацааны хэлэлцээний үр дүнд тохиролцож ИЗБНН-д 5 тойрог, МАШСН-д 20 тойрог, АН-д 51 тойрог хуваасан билээ. Гэвч энэхүү оногдсон тойргууд дээр намууд хэр амжилттай өрсөлдсөн нь сонгуулийн дүнгээс харж болно. Тухайлбал ИЗН өөрт оногдсон 5 тойргийнхоо 2-т нь ялалт байгуулж, сонгуульд 40 хувийн амжилт үзүүлсэн бол, МАШСН 20 тойргийнхоо 7-д нь ялалт байгуулж 35 хувийн амжилт үзүүлжээ. Харин АН 51 тойргоос 27-д нь ялалт байгуулснаар 53 хувийн амжилтанд хүрчээ. Эндээс харвал хамгийн амжилтгүй оролцсон нь МАШСН ба ИЗН түүнээс арай дээр байна. Тиймээс эдгээр намуудад хэт олон тойрог хуваарилсан гэсэн шүүмжлэл намын дарга М.Энхсайхан сонсох нь зүй ёсны юм. Нэн ялангуяа бие даан нэр дэвшиж ялалт авчирсан Р.Амаржаргал, Д.Одхүү, Я.Санжмятав нарын хувьд. Гэвч түүний хийсэн хамгийн гол алхам бол эдгээр намуудыг эвсэлд нэгтгэж чадсан явдал бөгөөд ингэснээрээ санал хуваах аюулаас зайлсхийж сонгуульд амжилттай оролцжээ.

Харин МАХН-ын зүгээс сонгуульд хэт бардсан тал бий. Тэд цалин тэтгэврийг мэдэгдэхүйц нэмсэн, их өрийг тэглэсэн, инфляцийг нэг оронтой тоонд барьж чадсан, төсвийн алдагдлыг бууруулсан, эдийн засгийн өсөлтийг бий болгож чадсан, СоцИнтернд элссэн, Мянганы замын бүтээн байгуулалт, Бүх аймгийг Мобикомын сүлжээнд холбосон гэх мэт зүйлээр рекламдаж, хэт бардсанаас нэр дэвшигчдийг сонгоход хүртэл зарим нэг алдааг хийсэн. Мөн сонгуулийн сурталчилгаага хэт эрт дэндүү эрч хүчтэй эхэлснээр энэхүү далайц нь сонгууль дөхөх тусам буурсан гэж зарим судлаачид дүгнэдэг¹⁴⁹. Эдгээр хүчин зүйлс мэдээж нөлөөлсөн, хамгийн гол нь сөрөг хүчин эвссэн тохиолдолд иймэрхүү үр дүн гарч болзошгүй байсныг тооцоолох ёстой байв. Хэрвээ үүнийг анхаарсан бол МАХН-д одоогийнх дээрээ ядаж 3 суудал нэмээд авчих нөөц, боломж байсан. Тухайлбал Завханд Д.Оюунхоролыг, Улаанбаатарт М.Энхболд гэх зэрэг хүмүүсийг өрсөлдүүлсэн бол олонхи болж чадах байв.

Эцэст нь дүгнэхэд хэрвээ сонгуулийн хууль болон хүчний хуваарилалт багцаагаар өнөөгийнхтэй ижил нөхцөлд МАХН болон Ардчилсан хүчин (ардчилсан хүчний намууд эвссэн тохиолдолд) сонгуульд голлох суудал авах бөгөөд сонгуулийн дүн пропорциональ системтэй ойролцоо дүнтэй гарна. Харин Ардчилсан хүчин задарч намууд тус тусдаа сонгуульд өрсөлдвөл МАХН-д ашигтай, өөрөөр хэлбэл 1992, болон 2000 оны сонгуультай адилаар МАХН-ын үнэмлэхүй ялалтаар өндөрлөх боломжтой гэсэн таамаглал бидний судалгаагаар нотлогдож байна.

149 Ч.Тамир. Хөвдөг сонгогчид ба улс төрчдийн хувь заяа. "МН-Өнөөдөр" 2004-7-22.